

“ОРХОН ХӨГЖИЛ” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 он 03 сар 17 өдөр

Дугаар: 02

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйл, 64.2 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар мэдээг хүргэх журмын 2.1, 2.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Орхон Хөгжил” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04-р сарын 28-ны өдрийн 11 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, ЮБ март худалдааны төвийн 5-р давхарт 519 тоот өрөөнд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөр тогтоосугай.
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 2. 2025 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах;
 3. Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг батлах,
 4. ТУЗ-ын ногдол ашиг тараахгүй талаар гаргасан тогтоолыг хэлэлцэх,
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг **2025 оны 03-р сарын 21-нд өдөр тутмын 2-оос доошгүй сонин хэвлэл болон МХБ-ийн сайтаар; 2025 оны 04-р сарын 07-нд хэвлэл мэдээлэлийн зарыг дахин давтан, 2025 оны 3-р сарын 26 өдрийн дотор брокерийн компанид хүргүүлэх зэргээр хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.**
5. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг хурал хуралдах өдрийн буюу 2025 оны 4-р сарын 28-ны өдрийн 11 цагаар тасалбар болгосугай.
6. Ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ны агуулгыг Хавсралт 1-р, Хурлын дэг, бичиг баримтын жагсаалтыг Хавсралт 2-р тус тус баталсугай.
7. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг хурлаас өмнө бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс -д даалгасугай.

8. Хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргэхтэй холбогдон гарах зардлыг нотлох баримтыг үндэслэн компаниас гаргуулсугай.
9. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах комиссийн даргаар Г.Урантогос, гишүүнээр Д.Жаргалсайхан, Тооллогын комиссийн даргаар Х.Сарнай, гишүүнээр Ч.Нарантуяа нарыг тус тус томилсугай.
10. “Орхон Хөгжил” ХК -ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг Санхүүгийн Зохицуулах Хороо, “Монголын Хөрөнгийн Бирж” ХК-д хүргүүлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ОЮУНЖАРГАЛ